<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>251559131.47</b>	<b>387975410.22</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>83044400.00</b>	<b>157608250.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>83044400.00</b>	<b>157608250.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	83044400.00	157608250.00
223001	Бусад хөрөнгө	71750000.00	147931450.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11294400.00	9676800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-83044400.00</b>	<b>-157608250.00</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	100671500.00	48425180.00
230001	Эргэж төлөгдөх зээл	100671500.00	48425180.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-100671500.00</b>	<b>-48425180.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	67843231.47	181941980.22
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	123494345.88	191337577.35
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	191337577.35	373279557.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1956397200.00	1865658044.58
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1735210600.00	1694301414.58
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1693620300.00	1655036374.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1108884700.00	1097757437.12
210101	Үндсэн цалин	814770900.00	801678451.33
210102	Нэмэгдэл	204214800.00	211264448.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5054000.00	4856919.71
210104	Урамшуулал	67180100.00	63383877.34
210105	Гэрээт ажлын хөлс	17664900.00	16573740.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	154637900.00	148959329.87
210201	Тэтгэврийн даатгал	110183600.00	108159453.13
210202	Тэтгэмжийн даатгал	11234600.00	10307727.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	8858700.00	8230565.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2214600.00	2464042.52
210205	Эрүүл мэндийн даатгал	22146400.00	19797542.04
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	255363600.00	251293425.59
210301	Гэрэл, цахилгаан	14138400.00	12911477.59
210302	Түлш, халаалт	240536600.00	238331948.00
210303	Цэвэр, бохир ус	688600.00	50000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	57324400.00	55362870.00
210401	Бичиг хэрэг	6818000.00	6808092.00
210402	Тээвэр, шатахуун	37454800.00	36236090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7110700.00	6691100.00
210404	Ном, хэвлэл	1179900.00	1025000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	444800.00	572450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4316200.00	4030138.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	60061300.00	49310590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17890100.00	17883690.00
210502	Хоол, хүнс	38344500.00	27600600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3826700.00	3826300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5855500.00	5854850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	579500.00	579500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	230000.00	230000.00
210604	Урсгал засвар	5046000.00	5045350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6705100.00	5614800.00
210702	Догоод албан томилолт	6705100.00	5614800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6996200.00	6188850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3263300.00	3182908.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1907100.00	1786300.00
210803	Даатгалын үйлчилгээ	539100.00	233350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295700.00	187420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88600.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203400.00	203400.00
210807	Газрын төлбөр	188300.00	178772.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60700.00	33000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450000.00	383700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37791600.00	34694222.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23782200.00	20782200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14009400.00	13912022.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	41590300.00	39265040.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	41590300.00	39265040.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13215000.00	11429740.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27335300.00	27335300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1040000.00	500000.00

**Ургамал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>106715600.0</b>	<b>122931450.0</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	106715600.0	122931450.0
223001	Бусад хөрөнгө		122931450.0
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>114471000.00</b>	<b>48425180.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	114471000.00	48425180.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1956397200.00</b>	<b>1900850741.13</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1015100200.00</b>	<b>997555487.99</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1015100200.00	997555487.99
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>792251500.00</b>	<b>787296113.14</b>
122005	Орон нутгийн төсвөөс	690535900.00	685580593.14
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	101715600.00	101715520.00
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>13074500.00</b>	<b>13074500.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13074500.00	13074500.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>135971000.00</b>	<b>102924640.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86534200.00	102924640.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	49436800.00	
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>73919335.50</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>109112032.05</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>93.00</b>	<b>93.00</b>
620001	Удирдах ажилтан	13.0	13.0
620002	Гүйцэтгэх ажилтан	52.0	52.0
620003	Үйлчлэх ажилтан	25.0	25.0
620004	Гэрээт ажилтан	3.0	3.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>166544814.27</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>141544814.27</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>69653240.27</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>0.00</b>	<b>454938.00</b>
210301	Гэрэл, пахилгаан		454938.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>8291495.27</b>
210401	Бичиг хэрэг		375787.27
210402	Тээвэр, шатахуун	-	5,700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		123708.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2092000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>38875619.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	33,439,539.00
210502	Хоол, хүнс	-	5,436,080.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>33150.00</b>
210604	Урсгал засвар		33150.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>308000.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	308,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.00</b>	<b>3357104.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3357104.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>18332934.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,983,434.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		349500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>65844415.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>65844415.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		37487628.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	28,356,787.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>6047159.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		6047159.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>25000000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	25000000.00
223001	Бусад хөрөнгө		25000000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>223254385.27</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>223254385.27</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		40411290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		182643095.27
131106	Төсвийн урамшуулал		
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)-(I)</b>		<b>56709571.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		56709571.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ургамал сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Гэрэлт-Од-д танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ургамал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжлийн төлөө ажиллахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ын үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 2,950.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 44.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75% буюу 33.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	191.3	373.3	182.0
Авлага	189.2	250.6	61.4
Бараа материал	164.8	200.9	36.1
Үндсэн хөрөнгө	1,622.2	1,561.1	(61.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,167.5</b>	<b>2,385.9</b>	<b>218.4</b>
Өр төлбөр	25.8	24.4	(1.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,141.7	2,361.5	219.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,167.5</b>	<b>2,385.9</b>	<b>218.4</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 182.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 48.7 хувиар өссөн байна. Энэ нь СХС, ОНХС, орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 61.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд байгууллага болон хүмүүсээс авах авлага байна.

Байгууллагаас авах авлага буюу төлбөртэй үйлчилгээ болох ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд авлага үүссэн байна. Дараах байгууллагуудын авлага нэмэгдсэн байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЗДТГ	98,678.20	-
ИТХ	25,432.98	33,511.77
ЭМГ	3,753,780.30	106,336,810.68
Сургууль	1,748,211.87	1,400.00
Цэцэрлэг	2,192,858.01	-
Соёлын төв	-	1,178.90
СХсан	181,418,550.00	144,238,190.00
ОНХсан		
Төрийн сан		
<b>ДҮН</b>	<b>189,237,511.36</b>	<b>250,611,091.35</b>

**Илрүүлэлт:** ТШЗ-ын аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 164.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.4 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 36.1 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын бараа материалын худалдан авалт их байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 61.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 219.8 сая төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 1,956.3 сая төгрөгөөр тоохон төлөвлөж баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,956.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,735.2 сая төгрөгийг урсгал зардалд, 106.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 114.4 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,015.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 690.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 101.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 13.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 86.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 49.4 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 997.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 685.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 13.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 101.7 сая төгрөг, 102.9 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,900.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 55.5 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 114.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 48.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,900.8 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 23.1 сая төгрөгийг сумын төсөвт, 14.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 223.2 сая төгрөгийн санхүүжилт авч бараа, ажил үйлчилгээний зардалд 69.6 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 28.4 сая төгрөг, хөдөө ОНТША албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 37.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 25.0 сая төгрөгийг тус тус зарцуулж 6.0 сая төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн аудитаар 4 байгууллага “Сөрөг” санал дүгнэлт авсан, ОНХСангийн журмын дагуу ажилладаггүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус төвлөрүүлэн захирагчийн харъяаны байгууллагуудын захирал, эрхлэгч нарт үр дүнгийн урамшууллыг журмын дагуу олгоогүй, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас биеийн тамирын хувцас худалдан авах гүйлгээг төрийн сан хийсэн, ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн мал нядалгааны байр байгуулах ажлын гүйцэтгэл дуусаагүй байхад мөнгийг бүрэн шилжүүлсэн, 20 айлын орон сууц барих газрын зураг төсвийн үнэ шилжүүлсэн ч зураг төсвөө аваагүй, гамшгаас хамгаалах санд шилжүүлсэн мөнгөний анхан шатны баримтгүй зэрэг зөрчил илэрсэн нь санхүүгийн албаны хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс 129 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 26 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ургамал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

ОНХСангийн журмын дагуу ажилласан эсэхийг нягтлан шалгах.

## **4. Аудитын илрүүлэлт**

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн аудитаар нийт 1.6 сая төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж илэрсэн.

### **4.2.1 Залруулсан алдаа**

Аудитаар залруулгын алдаа илрээгүй болно.

### **4.2.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

### **4.2.3 Албан шаардлага**

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

### **4.2.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1 Хяналттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Зардлыг зориулалт бус зарцуулж цэцэрлэгийн ажилчдад тэмцээний хувцас худалдан авсан гүйлгээг хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх" гэсэн заалт, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах.

#### **2 Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

*Илрүүлэлт:* Төвлөрүүлэн захирагч нь сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын үр дүнг 77 хувиар дүгнэж, урамшууллыг 30 хувиар бодож олгосон зөрчил илэрсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.1. “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.” гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах.

### **3 Нийцлийн аудитын асуудал**

**Илрүүлэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлээгүй, мөн төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлдээгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, ЗГ-ын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн алдаа зөрчлийн нэгтгэлийг доорх хүснэгтээр нэгтгэв.

№	Шалгагдагч байгууллагын нэр	Заглуулга		Нийт алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ургамал сумын Эрүүл мэндийн төв	2	105.69	4	177.34	2	171.37	0	0.00	2	5.97
2	Ургамал сумын хүүхдийн цэцэрлэг	2	0.77	5	4.84	5	4.84	0	0.00	0	0.00
3	Ургамал сумын Соёлын төв	0	0.00	1	1.20	1	1.20	0	0.00	0	0.00
4	Ургамал сумын ЗДТГ	2	11.99	7	11.06	3	2.76	1	3.80	3	4.50
5	Ургамал сумын ЕБС	6	43.60	3	14.27	2	2.84	0	0.00	1	11.43
6	Ургамал сумын ОНХС	0	0.00	3	36.00	0	0.00	0	0.00	3	36.00
7	Ургамал сумын СХС	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
8	Ургамал сумын ИТХ	1	2.31	4	3.26	3	2.06	0	0.00	1	1.20
9	Ургамал сумын Засаг дарга	0	0.00	3	1.63	0	0.00	0	0.00	3	1.63
	<b>Дүн</b>	<b>13</b>	<b>164.36</b>	<b>30</b>	<b>249.60</b>	<b>16</b>	<b>185.07</b>	<b>1</b>	<b>3.80</b>	<b>13</b>	<b>60.73</b>

### БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Д.БАТ-УНДРАА	2022.03.24
АУДИТЫН МЕНЕЖЕР	Б.ДАГВАСҮРЭН	2022.03.24
АХЛАХ АУДИТОР	Б.ЖАЛБАА	2022.03.24

#### БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	Г.БААСАНЖАРГАЛ	2022.03.24
---------	----------------	------------